

“ХЭРЭЭ ШААЗГАЙ ДОНГОДСОНЫГ ҮЗЭХ БИЧИГ ОРШИВ” СУДРЫН ТУХАЙ

До.Цэнджав¹

Ийм нэгэн нэртэй авсаархан жижиг судар хэр олон гарсан, хэр зэрэг судалсаныг энэ их номын далайгаас олж харсангүй. олж үзээгүй болохоос энэхүү судрыг хэвлэсэн ч байж магад. Бидний олонхийн санаж боддогээр хэрээ гэдэг шувуу цаанаа л ёр билэггүй, муу зүйлд урин дууддаг, үхээрийн жигүүртэн гэсэн ойлголт аман яриа, утга зохиол, уламжлалт зан үйлд байдгийг арай өөр талаас нь харвал яасан бэ? гэдэг санааг дэвшүүлж, хэрээ гэдэг шувууг мэт амихандаа нээхийг хичээлээ. Чингис хаан чоно, хэрээ хоёрын төр түмэндээ үнэнч шударгын бэлгэ тэмдэг хэмээн үздэг байсан хийгээд ХХ зууны бөө нар хэрээг лусын хаадын хэлмэрч, чоныг онгодын гурхирга, бас унаа зарц гэх мэтээр авч шүтдэг гэж ихэд дээдэлдэг байна. (О.Пүрэв “Монгол бөөгийн шашин. 2 дахь хэвлэл. УБ 1999 он 232-р тал) Иймээс хэрээ шаазгай хоёр бол тэнгэрийн бусад амьтад цөм дэлхий дээр байдаг лус савдагийн амьтад учраас тэнгэрийн орон байрыг шувууны дор, лусын хаадын байрыг бусад амьтдын дор байрлуулан дүрсэлдэг байна. Ер нь бөөгийн шашинд хэрээ шаазгайг онгод тэнгэрүүдийн хувилгаан дүр, нөгөө талаар онгод тэнгэрийн өмч гэж үздэг байх юм. Хэрээ шаазгайны үлгэр, домогтой холбоотой судалгаа бүтээлүүд мэр сэр байдаг бололтой. “Профессор С.Дуламын бүтээлийн жагсаалтад” (УБ. 2008) байна.

Долгормаа гэдэг эмэгтэйг хаа ч явсан хэрээ үргэлж дагадаг, тааралддаг, байсхийгээд хэрээ зүүдэлдэг, янз бүрийн авиа гаргадаг тухайгаа ярьсан нь сонин хачин санагдсан юм. “Тэгээд муу юм тохиолддог уу?” гэж асуухад “Үгүй шүү, харин ч надтай хөөрөлдөөд элдвээс муугаас сэрэмжлүүлээд, сайн муу мэдээ дохио зангаа өгөөд байх шиг санагддаг” гэсэн юм. Өөрөө ч бас жирийн нэгэн удмын хүн биш бололтой. Түүний аав алдартай лам, бурханч уран гартай нэгэн байжээ. Өвгөн лам бурхан тахилаа нуулгүй ил залдаг тэр үеийн сайд гомчуул хүртэл нууцаар бишгүй ирдэг байж.

Нэгэн сонин зүйлийг их хурлын гишүүн асан Б. Шаравдорж хуучилсан юм. Манай Дорноговийн Хөвсгөл суманд Бөмбөөлэй гэдэг хөгшин саявтархан болтол байсан. Их урт насалсан. Тэр нэг удаа хөлөө хөл нь хугарсан хэрээтэй тааралдаад гэртээ авчирч, араганд хийж эмчилжээ. Хүн хэрээ хоёр салалгүй хамт байж, бас ч болоогүй хэрээний ойр зуурын авиа хэлийг мэдэрдэг болсон юм байх. Хэрээг эдгээгээд суллаж тавихад гэрээс холдохгүйгээр үл барам хөдөө гээсэн чөдөр ногт зэргийг олоод ирдэг болсон гэнэ. Бөмбөөлэй гуай айхтар өвчин тусаж, сумын эмнэлэгт хэвтжээ. Эмчилгээгүй гэжээ. Эмнэлэгийн цонхон дээр нөгөө хэрээ ирчихсэн, хүмүүсийн гайхшийг баржээ. Аймгийн эмнэлэгт хэвтэхэд бас л эмчилгээгүй гэж. Харин нөгөө хэрээ түүнээс салахгүй цонхон дээр нь ирчихсэн гуаглаж байж. Аргаа бараад

1. Монгол Улсын Их Сургууль

До.Цэнджав

“сайд нарын” гэгдэх хоёрдугаар эмнэлэгт биеэ үзүүлж, эмчлүүлжээ. Нэг хэсэг говийнхныг хоёрдугаар эмнэлэгт үздэг байснаа сүүлдээ энэ нь байхгүй болсон. Гэтэл нэг өглөө цонхон дээр нь мань хэрээ дуугарахаар нь гайхаад хартал нөгөө агуу анд хоёулаа болчихсон тагтан дээр нь сууж байжээ. Ингэж хэрээ түүнийг хаа явсан газар дагаж, улмаар Бөмбөөлэй гуайн бие нь илааршсан юм. Юм хачин шүү. Энэ үнэн явдал” гэж хөөрсөн юм. Ийм домог шиг зүйлийг сониноос уншиж байсан ч тэрхүү зүйлийг хайчилж хадгалаагүй нь харамсалтай санагдана.

Бас нэгэн тохиол. Дундговь аймагт жараад оны дундуур аймгийн намын хорооны нарийн бичгийн даргаар ажиллаж байсан Д. Очирбат гэгч хүнийг хэрээ, шаазгайны хэлийг мэддэг гэсэн яриа миний чихийг дэлсэж билээ. Энэ хүн бол хожмоо эрдмийн зэрэг хамгаалж, Улсын номын сангийн дарга хүртэлх чухал алба хашиж байв. “Далны мэргэ” зэрэг мэргэ төлөгний цөөнгүй ном бичсэнийг мэдэх нэг нь мэдэх байх. Сонин авир зантай тэрбээр ерээд оны дундуур мэргэ төлгө, амьтдын зурхай судлаач гээд явдаг байсан ч ярилцаж яваагүй нь одоо харамсалтай санагдаж байна. Тэрбээр хөдөө явж байгаад “Алив зогс, энэ хэрээ юу гэж байна мэдээдэхье” гээд машинаасаа үсрэн бууж чагнаад “За хө, буцаад тэр толгойг даваадах...” гэхэд “Манай даргад номын хүдэг тусаж, цагаан солиотой болж байгаа юм болов уу” гэж жолооч нь бодоод дурамжхан ч гэсэн хаагуур явахыг дарга мэддэг жамтай болохоор тэр товгыг давтал үснээс нь гал маналзмаар суналзсан сайхан шаргал үнэгтэй таарч олз омогтой явсан шүү. Манай Ообо дарга жирийн бишээ” гэж байв. Өмнөговь аймгийн нэгэн сүрхий номтой лам хэрээний хөл, магадгүй энэхүү судрыг мэддэг ч байсан байж болох. “За ер нь хэрэг бишгэдлээ. Тун даруй ууланд оргож гарахгүй бол амь насанд аюултай байна” гэж хэлээд явсаны хойхно ногоон малгайтны төлөөлөгч ирсэн гэсэн яриаг ч сонсож байлаа.

Ганц энэ тохиол бишээ, намайг Өндөршил суманд ажиллаж байхад “жони” хэмээх Лувсандорж гэгч энгэрээрээ дүүрэн загал буурал сахалтай, хөдөө гадаагуур тэнэж юу тааралдсанаа цуглуулдаг үхэхээс бусдыг үзсэн тэр өвгөн надад “Ах нь бага залуудаа бадарчилж Утай Гүмбэн орж явлаа. Аян замд хон хэрээ мөн ч түшиг хань болдог амьтан шүү. Чалчих нь хэцүү ч тустай дэмтэй, сайн муу мэдээ зангийг газрын хаа холоос өгнө шүү дээ. Хэрээний хэлийг ойлгох шиг амархан зүйл үгүй. Би хээрийн боохойн хэлээр харилцаж, дагаад салахгүй болохоор нь муу улианыг хэвтүүлчихдэг байж билээ” гэж хөөрч байсан. Энэ бол чихээр сонссон яриа. Энэ буюнтай өвгөн гайхамшигтай үзмэргэй музейг сумандаа байгуулж, хөдөөгүүр тэнэж явахдаа жонш, нүүрсний уурхайг нээж улсын тэргүүний геологич болж явсныг тэр нутгийнхан андахгүй. Мэргэ төлгөнд “Хэрээ буувал хэрэг түргэн бүтнэ, хэл чимээ удалгүй ирнэ” гэж буудаг.

Нэрлээд яахав дээ, хэн хүнгүй таньж мэдэх генералын нүд юм үзэхээ байгаад миний ташил зохиолчид хэрээний нулимс сайн гэнэ, чамд туслах арга байна уу? гэжээ. Тэр зохиолч маань Тэрэлжийн гол хавиар олон жил өвөлжиж, зуншдаг Нужирбек гэгч казакаар хэрээг амьдаар бариулж бахируулан нулимсыг нь дусаалгасан гэдгээ надад ярьсан. Тэр казагыг би ч мэднэ, танина. Юунаас ч үл айх зоригтон гэдэг бол тэр байгаа юм. Ээ бурхан минь, түүн шиг муухай аюултай зүйл байхгүй юм билээ. Хэрээний тарчлах хашгирах дуу хэдэн өдөр чихэнд явсан. Генералын нүд овоо хараа орсон ч нэг их удаагүй. Гурван зуун настай амьтныг хороосондоо гутаж явдаг. Надад харин гай цээр нь ирээгүй гэж ярьж билээ.

“Хар өнгө” гэдэг бол монгол утга соёлд домог зүй, бөө мөргөлийн зүүн зүгийн дөчин дөрвөн тэнгэрийн өнгө зүс, түүнтэй холбоотой муу үйлийн өнгө болох учир буй” (С.Дулам “Монгол өнгийн бэлгэдэл зүй” Уб. 2007. 7-ртал) Иймээс хар хэрээ монголчуудын сэтгэлд төдий л сайн сайхны өнгө бэлгэдлээр буудаггүй нь цаанаа учиртай. Энэ бүхнийг эс өгүүлэн “Хэрээ шаазгайн донгодсоныг үзэх бичиг оршив” бяцхан судрын зарим үг гаргац муутай төдийгүй, одоогийн хүн ухахад бэрх ганц нэг үг тааралдсанаас өөр зүйлгүй, харин ч ихэд утга тодорхой байсанд олзуурхав.

До.Цэнджав

Ардын аман зохиол, зүйр цэцэн үг, хэлц хэллэгт хэрээг гаднах хар өнгөтэй нь л холбогдуулан өөчилж гоочилж, ёжилж, гүтгэж, нүд үзүүрлэж, жигшиж бичсэн зүйр үг цөөнгүй. “Хэрээ хэрээнийхээ харыг гайхах”, “Хэрээ цайдаггүй хэрэг хуучирдаггүй”, “Хэрээний сүргээс мултравч тогосны сүрэгт эс нийлэх” “Хэрээ тонших зовлоггүй, хиншүү гаргах нүнжиггүй” “Хэрээнд харвасан сум зараанд тусах, зарааны хахсан хорхойд тусах”. “Хэрээ гахай дээр суугаад чи яасан хар юм бэ? гэх”, “Хэрээ өтлөвч бууралтахгүй, хэрэг удавч цайрахгүй”, “Хэрээ алаад хэзээ ч хоосон, шаазгай алаад шалдан”, “Хэрээ галууг дуурайж хөлөө хөлдөөв”, “Хэрээ мянган жил боловч хар хэвээрээ”, “Хэрээ ниссэн газар улай тасрахгүй, хэрүүл болсон газар хэл ам тасрахгүй”, “Хэрээ харцаганы зиндаанд хүрэхгүй, хэрээн өөхний зиндаанд хүрэхгүй”, “Хэрээ хэрээнийхээ нүдийг тоншдоггүй, хэлтэн хэлтэнийхээ хэлийг огтолдоггүй”, “Хэрээ шиг хар, хир шиг бузар”, “Хэрээнд идэхгүй мах үгүй ч, хэрээний махыг идэх амьтан байхгүй, хэрүүлчид хэлэхгүй үг байхгүй”. “Хэрээнд нүд өгөхөд хөмсөг гуйв гэх шиг”, “Амташсан хэрээ арван гурав дахина”, “Хэрээний нүд залгих” “Галуу дуугарвал ган болдог, хэрээ дуугарвал чоно ирдэг”, Зовлого болбол хэрээ баясна, зовлон болбол наймаачид баясана”, Муу хүн хэрэлдэхгүй хүнгүй, хар хэрээ суухгүй модгүй”, “Хар хэрээ цагаан болохгүй, хамаг амьтан бурхан болохгүй”, “Хар хэрээ улай дээр, харгис ноён жинсэнд дуртай”, “Хон хэрээ дуугарвал ховдог чоно ирдэг”, “Хон хэрээ хоосон хашгирдаггүй, хонь мал хоосон үргэдэггүй” гэхчилэн нэг л таашаал муутайхан хандаж иржээ.

Хэзээд жаргах хувьгүй муу амьтанд

Хэдий юм бий боловч эдэлж чадалгүй зовьюу

Хэрээ хэдий өлсөвч өлсноо булж тавина

Хирдээ цадталаа идэж амаржих маш цөөн гэж алдарт Сажу Банлид Гунгаажалцаны “Субашид” хэмээх эрдэнийн сударт ч байх юм. Бага балчир байхад “За чи хээр хөдөө унтаж байгаад хурга ишигнийхээ нүдийг үхээрийн хэрээнд ухуулчихав” гэсэн зэм сонсдогсон.

Ерийн сэтгэхүйд улай үзэгч хэрээ таатай сайхан шувуу биш ч гэлээ эртний уран зохиолд нааштайгаар дүрсэлсэн нь тааралдана. “Ногоон дарь эхийн туужид” хэрээг дээд диваажин, там, доод газрын хаана юу байгааг нэгд нэгэнгүй мэддэг сайн муу бүхнийг нэгжин харж, мэдээ занги хэл чимээ өгдөг тусч амьтан гэдгээр дүрслэн харуулсан байх юм. Ногоон Дара эх насаараа даяанчилсан боловч бурханаас гуйж мөргөсний эцэст сайхан хүүтэй болдог. Гэтэл төд удалгүй хүү нас барж уйтгар гунигийн далайд живж байна. Хүүгээ Сайн цагийн мянган бурханы орон, дунд замбутив, тамын орон, мөн гадаад далайг шүүрдэн хайгаад ололгүй бишгүүр мэт дуугаар хайлан явтал хон хэрээ тааралдаж байх юм. “Зургаан зүйл хамаг амьтны эх болсон Ногоон Дарь эх аль газар морилж явна вэ?” хэмээн асуухад ногоон Дарь эх сайхан бодисад хүүтэй болсон хийгээд түүнийгээ алдчихаад хайгаад олохгүй яваагаа хэлэхэд, “Алтан уулын орой дээр долоон үе номын чанар бясалгасан, ерэн есөн жилийн даяан хийсэн есөн хэлийг мэдэх огторгуйн Мэргэн цагаан арш бээр хар цагаан зурхай зурж, хар цагаан чулуу тавьж байхыг үзэв. Тэр мэдэх буйзаа” гэнэ. “Ээ чи миний замыг зааж мөрийг шулуутгаж өгсөнөөр “Жаварт тэнгэрт даарахгүй биетэй болоорой, жаран жалгыг нэвт харах нүдтэй болоорой” хэмээгээд усан нүдний оронд билгийн нүдийг өгөн соёрхож байна. Энд нэгэн сонин зүйл ажиглагдаж байна. Тэр бол “усан нүдний оронд билгийн нүд заяалаа” гэж байгаа нь үргэлж хав хар муу муухай юмыг үзэж харж явахын оронд гэрэлт сайн сайхныг харж үзэж түүнээ цагаан мөрөөр түгээж явтугай гэсэн нь хэрээний мөнхийн чанарыг өөрчлөн адислаж байгаа нь нэгийг хэлж байна.

Харин манай орчин цагийн зохиолч, уран бүтээлчид болохоор мөнхийн муу ёрын дагуул, мөнхийн муу муухайн тотем, мөнхийн муу муухай үг хэллэгийн гол баатар хон хэрээ

До.Цэнджав

болсоор ирсэн. Үзэгдэх өнгөнд хууртаж явдаг хорвоо хойно, үүнийг зөв гээд ч яахав, бас буруу гээд ч яахав. “Магтая гэвч, уруул давахгүй” гэсэн үг бий. Үүнийг ч миний бие хуваалцана. Гэвч бас хааяа хааяа арай өөр нүдээр харж, хавь орчноо соргог нүд, цочмог ухаанаар шүүн ажиглаж, энэ тэр элдэвтэй дүйцүүлж, байгаль, ан амьтан, хүмүүний нууц далд холбоо, сонин гаж үзэгдлийг тайлж болох юу магад хэмээн энэхүү судрыг бүрэн эхээр нь буулгалаа.

Төвдийн хааны хэрээ тайлахыг үзэх бичиг буй. “Хан хан” донгодвоос сайн үг сонстох, “тан тан” донгодвоос аливаа үйл бүтэх, “хон хон” донгодвоос идээ ундаа авчрах буй. “Хай хай” донгодвоос аливаа хүн айх, хурдан хэл ирэх, “Тон тон” донгодвоос их ноёдын чуулган чуулах. Дорвон зүг ... (ихэд балархай учраас гаргагдсангүй До.Ц) ирж донгодвоос жуулчин худалдаа ирэх. Өмнөөс донгодвоос идээн ацрах (Авчрах До.Ц)

Өрнөөс донгодвоос хүргэн охин ирэх. Умраас донгодвоос их сайн буй. Бас аливаа өлөрт дорноос барс, туулай цагт донгодвоос хүн юм ацрах. Луу, могой цагт олз түвэх (түгэх болов уу? До.Ц) баяр буй. Морин цагт донгодвоос зочин ирэх. Хонин цагт донгодвоос их муу. Бич, тахна цагт донгодвоос өчүүхэн хэл ам буй. Зүүн өмнөөс барс барс туулай цагт донгодвоос нус нулимс болох. Луу могой цагт донгодвоос сайн үг сонсох. Морь, хонь цагт донгодвоос гаднаас муу үг сонстох.

Өмнөөс барс туулай цагт донгодвоос их сайн. Луу могой цагт донгодвоос жуулчин хүн учрах. Морь цагт тэмцэх хэл ам буй. Хонь бич цагт донгодвоос холоос сайн хэл сонстох. Тахна цагт донгодвоос чухал ураг ирэх.

Баруун өмнөөс барс туулай цагт донгодвоос их сайн. Луу могой донгодвоос хан хүний шүтээн хүргэх. Морь хонь, бич тахна цагт донгодвоос бороо (буруу ч гэсэн үг байж магад До.Ц) болох. Тахна цагт донгодвоос ураг элгэн ирэх. Өрнөөс барс туулай цагт донгодвоос сайн үйл олон болох. Луу могой цагт донгодвоос хэл ам буй. Морин цагт донгодвоос холоос зочин ирэх.

Баруун хойноос барс туулай цагт донгодвоос архи уух. Лу умогой цагт донгодвоос хааны засаг зарлигт торох. Морь цагт донгодвоос дарс, идээн буй. Хонь бич цагт донгодвоос ураг ирэх. Тахна цагт донгодвоос эрэл олох. Умраас барс туулай цагт донгодвоос хэл ам буй. Луу бич цагт донгодвоос завхарсныг олох. Тахна цагт донгодвоос өвчин чир болох. Зүүн хойноос барс туулай цагт донгодвоос өвчин болох.

Луу могой цагт донгодвоос ураг ирэх. Морин цагт донгодвоос хүн юм ацрах. Хонь бич цагт донгодвоос их сайн. Тахна цагт донгодвоос өвчин чир болох буй за.

Шаазгай хулгана цагт донгодвоос амраг хүн золгох, сайн хүн ирэх. Үхэр цагт донгодвоос ер сэтгэсэн бүтэх. Барс цагт донгодвоос зовлон хэл ам буй. Туулай цагт донгодвоос архи ацрах. Эд идээт болох. Луу цагт донгодвоос холоос сайн зочин ирэх. Могой цагт донгодвоос хүн морь олох, сайн үг сонстох. Морин цагт донгодвоос өвчин болох. Тасарсан бурханаас гай буй. Гал тахиваас сайн буй. Хонин цагт донгодвоос адгуусанд хулгай дайсан үхэл болох. Бич цагт донгодвоос сайн үг сонссоноор өлзий хутаг болох. Тахна цагт донгодвоос сайн үг сонсох, дээд лам ирэх. Өлзий хутаг оршуул. Нохой цагт донгодвоос эд мал идээн ирэх. Гахай цагт донгодвоос хэл ам гай зэтгэр учрах.

Хааны засаг зарлигаас айх буй. Сэрэн хичээгдэхүй. Мангаалам.

Хэрээ шиг олноороо сүрэглэдэг, хаа сайгүй тааралддаг шувуу тэр бүр байхгүй. Говь, хангай гээд бүх газар орон, нутагт тархмал байдаг. Улаанбаатарт тагтаанаас олон. Дэлхийд хэрээгүй орон Антарктид, Шинэ Зеланд гэнэ. Хэрээний тухай ихээхэн шохоорхож, ултай баримт цуглуулж бичсэн эрдэмтэн бол Токиогийн их сургуульд багшилж байсан профессор Ж.Бат-

До.Цэнджав

Ирээдүй юм. Түүний өөрийн шавь докторант Хироюүки Нагаяамагийн хамт бичсэн “Жинхэнэ хэрээний тухай” өгүүллээс үзэхэд Японыг бараг хэрээний орон гэлцдэг нь үнэн юм байна. “Токиогийн их хэрэгтэйг яана. Ядаж байхад манай гэрийн хавьд цэцэрлэгтэй, цэцэрлэгээр дүүрэн хар хэрээ” гэж бичжээ. Япончууд хэрээгээ хөөрхөн шувуу гэж олон тааралддаг байна. Олонхи нь биш байх л даа. Хэрээг магтан дуулсан хүүхдийн хөөрхөн дуу байдаг тухай дээрх профессор бичжээ. Японы эзэн хааны өвөг дээдэс нийслэлд орж ирэхэд замч болж явсан гэрэлт сайн шувуу байсан гэнэ. Японы зарим шашин тухайлбал, жинжа (Шинто шашны сүм)-гийн зөн билэг нь наран дотор суугаа гурван хөлтэй хэрээ байдаг гэнэ.

Дэлхийн бүх бөө удганууд хэрээг өвөг дээдсийн ариун сүнснийг биедээ тээж яваа, ер бусын шидтэн гэж бишрэн дээдэлж үздэгийг өгүүллийн эхэнд дурдсан билээ. Бас буддын шашин ч хүндэлдэг байна. Бурхны шашны ёсны арван догшин сахиус Гомбо бурхны дагуул гэж үздэг юм байна. Ихээхэн хатуу тарнитай, догшин Гомбо бурхан нь хөх бараан, гурван улаан мэлмийтэй, таван хохимойг тэргүүндээ байрлуулж, 50 толгойгоор эрхи хийж зүүгээд, улаан шаргал үсээ хөх могойгоор зангидсан, эрэн могойгоор толгойгоо, ногоон толгойгоор хүзүүгээ, цагаан могойгоор бэлхүүсээ чимсэн цагаан гархиар хөлөө бөгжилөөд зааны арьс нөмрөн, зүүн хөлөө гадагш жийж, баруун хөлөө дотогш нугалсан, орой дээрээ бурхан залсан бадарсан галын дунд оршсон айхтар догшин дүрт бурхан байх юм. Ерөөс Гомбо сахиусыг хүн, малд тохиох гай барцадыг даруулах, түүнээс салгахын тулд урин залж, өргөл хүндлэл гүйцэтгэдэг юм байна.

Энэхүү судрыг ашигъя, тайля, туршъя гэвэл хэрээний хэлийг, дохио мэдээллийг мэдье гэвэл ердөө зүг чиг, цаг хугацаа гэсэн хоёрхон үндсэн чухал ойлголт л байна. Гадаадын моноох ухаант гэгддэг мэргэд байгалийн зүг чигийг ерөөс мэддэггүй мэл гайхаж, цэл хөхөрдөг бол монгол хүүхэд ухаан оронгуутаа л дөрвөн зүг, найман зовхисыг заагаагүй байхад аав ээжийнхээ “ярианаас л аандаа гайхалтай мэддэг болчихдог. Тэрийг баруун, знийг зүүн зүт гэж зааж зурж байгаа хөгшлийг үзээ ч үгүй, сонсоо ч үгүй. “Зүүн хойт уулын энгэрт байгаа үхэр авчир” гэхэд нусгай бор хүү гайхаж тээнэгэлзэх юмгүй шуудхан л гэр зүгт харван оддог нь монголын жирийн амьдрал. Энэ бол бас монгол ухааны л нэг маш өчүүхэн нь юм.

23-01 цаг- Хулгана цаг

03-05 цаг- Бар цаг

07-09 цаг- Луу цаг

11-13 цаг –Морь цаг

15-17 цаг- Бич цаг

19-21 цаг- Нохой цаг

01-03 цаг –Үхэр цаг

05-07 цаг- Туулай цаг

09- 11 цаг- Могой цаг

13-15 цаг- Хонь цаг

17-19 цаг- Тахиа цаг

21-23 цаг- Гахай цаг

Үзэгдэж харагдаагүй бүхэн хэрээнд сонин учраас дохио мэдээг үргэлж өгдөгийг хөөрхий хүмүүн бид даанч ажирч мэддэггүй. Хүчит бүргэд мэт зарим шувууд ямар ч авиа гаргаж чаддаггүй бол хэрээ тагнай таших нь ташиж, шогширох нь шогширч, шулганах нь шулагнаж хүний гаргадаг бүх авиаг гаргаж чаддаг байна. Хүмүүс 33 авиа гаргаж байхад хэрээ 46 орчим авиа гаргадаг гэж хэрээг олон жил судалсан ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн шувуу судлаач

До.Цэнджав

профессор Ш.Болдбаатар үзэж байна. Тиймээс хүний хэлийг тотьноос дутахгүй сурах шувуу хэрээ мөн боловч аль ч орны циркт сургуультай хэрээ байдгийг мэдэхгүй. Хэрээг тэжээж, “Чи миний найз” гээд л хэлээд байвал нэг л өдөр “Чи миний найз” гэж хэлж чадах увьдастай, гойд ухаантай шувуу гэдэг байна. “Хэрээг бүх шувууны зүйл дундаас хамгийн ухаантай шувуу” гэж тооцдог. (“Britannica” Нэвтэрхий толь 3774-р тал)

Хэрээг “нисдэг чоно” гэдэг. Хаана хоол байгааг чононд хэл дамжуулж үлдсэн сэг зэмээр хооллоно. Энэ нь анчинд ач тустай, бас жирийн малчдад ч мал сүргээ хамгаалахад ашигтай амьтан. Байгалийг цэвэрлэгч, хортон шавьжийг устгагч гэдэг утгаараа бол дуу найргийн манлай хун, хөхөөнөөс ч тустай гэж болохоор. Зохиолч би “Банхар” хэмээх богино өгүүллэгтээ аймшигт шуурганаар хоньтойгоо уруудаж алга болсон жаал хүүг хэд хоног сумаараа эрээд олохгүй байхад нутгийн нэгэн ажигч гяргай хүн хэрээ эргэлдээд байгаа газрыг зааснаар хүүг олсноор бичсэн. Энэ бол уран сайхны сэтгэлгээ биш, хүний ярианаас сонссон зүйлээ уран бүтээлдээ л ашигласан хэрэг. Хэрээг одооны хэлтэгээр “message” болгон ашиглаж болох юм. Сайн муу хэлийг хүмүүсг дамжуулдаг, дохио зангаа өгдөг хэрээ хэмээх амьтны хэлийг хэрвээ япончууд энэхүү судар шиг тайлж мэддэгсэн бол газар хөдлөх, далайн хар шуурга дэгдэх, их аадар асгаж, үерийн аюул учрах зэргийг мэдэж болох юм. Манайх ч энэ талаар огт тоож үздэггүй байна. Хэрээний хорт утаа болоод химийн ямар ч аюулт хий, бодисонд хордоггүй онцгой гайхамшигт махбодь, мөн чанарыг нээж, байгалийн шинжлэх ухаанд хосгүй нээлт гаргаж ч болох юм.

Харахад тас хар нэгэн төрлийн шувууд мэт боловч дэлхий дээр 20 төрлийн 100 зүйлийн хэрээ байдгаас манайд арваадхан байдаг. Хэрээг дан ганц хараар будаж ойлгож болохгүй нэгэн зүйл байна. Хэрээ хосоороо амьдардаг бөгөөд бие биедээ маш үнэнч шувуу юм байна. Нэгнээсээ үхэж хагацлаа ч дахиад “гэрлэдэггүй” үнэнч шувуу болохыг эрдэмтэд судалжээ. Бас тас шиг холыг хардаг. Сонгино хайрхан уулын оройгоос Туулын салаанд үхсэн жижиг амьтныг зовох юмгүй олж хараад нисч ирдэг байх юм. Хэрээ гэдэг шувуунаас багагүй зүйлийг нээж болмоор санагдана.

До.Цэнджав

НОМЗҮЙ

1. “Хэрээ шаазгай донгодсныг үзэх бичиг оршив” (Уйгаржин монгол дээр судар)
2. С.Дулам “Монгол өнгөний бэлгэдэлзүй” УБ . 2007 он, 7-р тал
3. О.Пүрэв “Монгол бөөгийн шажин” 2 дахь хэвлэл УБ 1999, 232-р тал
4. Гунгаажалцан “Субашилд”
5. Ж.Бат-Ирээдүй “Жинхэнэ хэрээний тухай” өгүүлэл
6. “Britannica” нэвтэрхий толь 2011 он 3724-р тал
7. Ш.Болдбаатар (вэйф сайт дээрх өгүүлэл)
8. До. Цэнджавын хувийн цуглуулга, архив

РЕЗЮМЕ

Писание на старомонгольском “Хэрээ шаазгай донгодсныг үзэх судар оршивой” ранее не публиковалось ни разу. Доктор и литературный критик До.Цэнджав написал это писание на кириллице, раскрыв множество интересных и редких фактов о вороне